



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**УЛСЫН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ**

2021 оны 4 дүгээр сар



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/05

Эрдэнэт

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаал, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгах, өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга /С.Батжаргал/-д зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, ахлах аудитор /В.Жавзмаа/, аудитор /Б.Бямбатогтох/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товъёг	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
БҮЛЭГ 1. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, орон нутгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй төсөл, арга хэмжээг УИХ-аар баталсаар байна.	8
<i>А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх арга хэмжээг авч байгаа хэдий ч орон нутгийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн тодорхойлж чадахгүй байна.</i>	8
<i>А.2 Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоог хууль, журамд нийцүүлсэн байна.....</i>	10
<i>А.3 УИХ-аар төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг баталсаар байна.....</i>	11
БҮЛЭГ 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт бүрэн хангагдахгүй байгаа нь төсөвлөлтөөс шалтгаалсаар байна.	13
<i>Б.1 Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг УИХ-аар баталснаас шалтгаалан гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажиллагаа төлөвлөсөн хугацаанаас хоцорсоор байна.</i>	13
<i>Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг 68.7%-тай хангуулсан боловч 2021 оны төсөвт 2 төсөл, арга хэмжээ батлагдаагүйгээс бүрэн дуусахгүй байхаар болсон байна.</i>	14
<i>Б.3 Захиалагчийн гэрээний хэрэгжилтэд тавих хяналтын үр дүн сайжирч байна.</i>	15
<i>Б.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар ЗГ-аас гаргасан шийдвэр үр дүнтэй байна.</i>	16
ДҮГНЭЛТ: 18	
Холбогдох байгууллагын санал:	20
Саналд өгсөн тайлбар:	20
ХАВСРАЛТУУД:	

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТХЯ	Зам тээвэр хөгжлийн яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИШС	Инженерийн шугам сүлжээ
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СЯ	Соёлын яам
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХББЗА ОНӨААТҮГ	Хот байгуулалт, барилга захиалагчийн алба орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭХЯ	Эрчим хүчний яам

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2020 онд батлагдсан төсөл, арга хэмжээ	7
Хүснэгт 2	Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтад баталсан төсөл, арга хэмжээ	7
Хүснэгт 3	Орхон аймгаас 2018-2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгах төсөл, арга хэмжээ	8
Хүснэгт 4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баталсан төсөл, арга хэмжээ	8
Хүснэгт 5	Санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүй баталсан төсөл, арга хэмжээ	11
Хүснэгт 6	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл	13
Хүснэгт 7	Төсөл, арга хэмжээний хэрэгжилт бүрэн дуусаагүй шалтгаан	14
Хүснэгт 8	2020 онд эрх нээж, олгосон төсвийн санхүүжилт	15
Хүснэгт 9	Урьдчилгаа төлбөрийн баталгаа болон барьцаа хөрөнгийн дансаар олгосон санхүүжилт	16
Хүснэгт 10	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2020 онд ашиглалтад хүлээн авч, бүртгэсэн хөрөнгө	16

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Батлагдсан төсөл, арга хэмжээ /салбараар болон төрлөөр/	8
Дүрслэл 2	Эрх шилжүүлсэн хугацаа хоцроосон байдал	12

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т аудит хийлээ.
Аудитын зорилт	Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх; • Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн ЗДТГ, аймгийн ГХБХБГ, ОНӨГ, ХББЗА ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг хамруулан шалгалаа.
Аудитын хязгаарлалт	Аудитын хязгаарлалт үүсээгүй болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 3000, тэдгээрт нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Үндэсний аудитын газрын харьяа Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа, аудитор Б.Бямбатогтох нар гүйцэтгэв. Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэж, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов тушаалаар баталгаажуулж, 2021 оны 05 дугаар сарын 05-нд УАГ-т хүргүүлээ.

Хүндрэл бэрхшээл

Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн өндөржүүлсэн болон бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын харьяа хэлтэс, албад, албан тушаалтан, ТАХ-г хэрэгжүүлэгч ААНБ-тай харилцахад цаг хугацааны хувьд хүндрэл үүссэн болно. Төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэл /хэрэгжилт/-ийг тулган баталгаажуулах ажил хийгээгүй болно.

БҮЛЭГ 1. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, орон нутгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй төсөл, арга хэмжээг УИХ-аар баталсаар байна.

А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх арга хэмжээг авч байгаа хэдий ч орон нутгийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн тодорхойлж чадахгүй байна.

Орхон аймагт 2018-2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 74 төсөл, арга хэмжээг баталжээ.

Хүснэгт 1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2020 онд батлагдсан төсөл, арга хэмжээ /сая.төгрөг/

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагчийн багц	2018 он			2019 он			2020 он		
		төсөл, арга хэмжээний тоо	төсөвт өртөг /сая.төг/	санхүүжих дүн /сая.төг/	төсөл, арга хэмжээний тоо	төсөвт өртөг /сая.төг/	санхүүжих дүн /сая.төг/	төсөл, арга хэмжээний тоо	төсөвт өртөг /сая.төг/	санхүүжих дүн /сая.төг/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1	50.0	50.0	2	4,000.0	4,000.0	3	6,972.3	2,600.0
2	Барилга, хот байгуулалтын сайд	5	14,998.6	4,388.7	3	6,400.0	5,400.0	3	7,400.0	4,732.6
3	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	10	16,070.5	7,003.4	15	21,878.7	14,628.7	8	7,962.0	2,289.5
4	Зам, тээвэр хөгжлийн сайд	1	3,000.0	1,500.0	4	12,052.9	6,500.0	2	9,052.9	2,552.9
5	Эрчим хүчний сайд	2	12,608.3	3,943.5	1	6,040.0	1,000.0	1	1,500.0	850.0
6	Эрүүл мэндийн сайд	2	130.0	130.0	1	500.0	500.0	2	1,908.0	1,158.0
7	Засгийн газрын хэрэг эрхлэх газар				3	6,000.0	4,000.0	5	9,960.0	2,560.0
Нийт дүн		21	46,857.4	17,015.6	29	56,871.6	36,028.7	24	44,755.2	16,743.0

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтад баталсан төсөл, арга хэмжээнд Орхон аймагт 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 44,755.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 24 төсөл, арга хэмжээг баталсан бөгөөд 24,278.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий шилжих 7, шинээр хэрэгжих 9 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлжээ.

Хүснэгт 2 Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтад баталсан төсөл, арга хэмжээ /сая төгрөг/

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагчийн багц	батлагдсан			эрх шилжсэн			эрх шилжээгүй		
		төсөл, арга хэмжээний тоо	төсөвт өртөг /сая.төг/	санхүүжих дүн /сая.төг/	төсөл, арга хэмжээний тоо	төсөвт өртөг /сая.төг/	санхүүжих дүн /сая.төг/	төсөл, арга хэмжээний тоо	төсөвт өртөг /сая.төг/	санхүүжих дүн /сая.төг/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	3	6,972.3	2,600.0	2	2,062.6	600.0	1	4,909.7	2,000.0
2	Барилга, хот байгуулалтын сайд	3	7,400.0	4,732.6	1	3,400.0	3,400.0	2	4,000.0	1,332.6
3	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	8	7,962.0	2,289.5	6	4,662.0	1,162.0	2	3,300.0	1,127.5
4	Зам, тээвэр хөгжлийн сайд	2	9,052.9	2,552.9	1	2,894.0	694.0	1	6,158.9	1,858.9
5	Эрчим хүчний сайд	1	1,500.0	850.0	1	1,500.0	850.0			
6	Эрүүл мэндийн сайд	2	1,908.0	1,158.0				2	1,908.0	1,158.0
7	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	5	9,960.0	2,560.0	5	9,960.0	2,560.0			
Нийт дүн		24	44,755.2	16,743.0	16	24,478.6	9,266.0	8	20,276.6	7,477.0

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөр, Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаартай уялдсан байна.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан 24 төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй нийцсэн байна. Эдгээр төсөл, арга хэмжээг тооны хувьд хэрэгжих салбарын болон

хөрөнгө оруулалтын төрлөөр авч үзвэл нийгмийн салбарын барилга байгууламж 50 гаруй хувийг эзэлж байна.

Дүрслэл 1 Батлагдсан төсөл, арга хэмжээ /салбараар болон төрлөөр/ /тоо, хувь/



Аймгийн Засаг даргаас 2018-2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад шилжих болон шинээр эхлэх төсөл, арга хэмжээг холбогдох судалгаа, тооцоонд үндэслэн орон нутгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, эрэмбэлэн холбогдох яамдад хүргүүлдэг байна.

Хүснэгт 3 Орхон аймгаас 2018-2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгах төсөл, арга хэмжээ

Төсвийн ерөнхийлөн захирагч	2018 он			2019 он			2020 он		
	Хүргүүлсэн ТАХ-ний тоо	УТХО-д баталсан ТАХ-ний тоо	Зөрүү	Хүргүүлсэн ТАХ-ний тоо	УТХО-д баталсан ТАХ-ний тоо	Зөрүү	Хүргүүлсэн ТАХ-ний тоо	УТХО-д баталсан ТАХ-ний тоо	Зөрүү
Барилга, хот байгуулалтын сайд	13	5	8	26	3	23	8	3	5
Эрчим хүчний сайд	7	2	5	8	1	7	10		10
Зам, тээвэр хөгжлийн сайд	6	1	5	9	4	5	8	2	6
Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	36	10	26	47	15	32	42	8	34
Эрүүл мэндийн сайд	10	2	8	9	1	8	20	2	18
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	2	1	1	7	2	5	2	3	-1
Засгийн газрын хэрэг эрхлэх газар	7		7		3	-3	4	5	-1
Хүнс, хөдөө аж ахуйн сайд			0	2		2			0
Хууль зүй, дотоод хэргийн сайд			0	1		1			0
Соёлын сайд			0			0		1	-1
Нийт	81	21	60	109	29	80	94	24	70

Эрэмбэлж хүргүүлсэн төсөл, арга хэмжээнээс жилд дунджаар 24 төсөл, арга хэмжээ буюу 26 орчим хувь нь улсын төсвийн хөрөнгө оруулалтад батлагдсан байна.

Хүснэгт 4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баталсан төсөл, арга хэмжээ /тоо, хувиар/

Хөрөнгө оруулалтын төрөл	2018 он		2019 он		2020 он	
	Холбогдох ТЕЗ-д хүргүүлсэн ТАХ-ний тоо	УТХО-д баталсан ТАХ-ний тоо	Холбогдох ТЕЗ-д хүргүүлсэн ТАХ-ний тоо	УТХО-д баталсан ТАХ-ний тоо	Холбогдох ТЕЗ-д хүргүүлсэн ТАХ-ний тоо	УТХО-д баталсан ТАХ-ний тоо
Шилжих	7	4	10	9	16	11
шинээр хэрэгжих						
барилга	40	12	58	17	21	8
их засвар	14	5	27	2	31	2
тоног төхөөрөмж	20		14	1	26	3
Нийт	81	21	109	29	94	24
Батлагдсан хувь		25.93		26.61		25.53

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт батлагдсан төсөл арга хэмжээнээс шилжих 1, шинээр эхлэх 7, нийт 8 төсөл, арга хэмжээнд аймгийн Засаг дарга санал хүргүүлээгүй бөгөөд УИХ-ын гишүүдийн санаачилгаар тусгагдсан байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн их сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон, Баян-Өндөр сум/,
- Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/,
- Ахмадын өргөөний барилга /Орхон, Жаргалант сум/,
- Багийн явган хүний зам, тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант, Цагаанчулуут, Наран, Даваат, Булаг, Баянбулаг, Уртбулаг, Бүрэнбүст баг/,
- Явган хүний зам, тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант, Цагаанчулуут, Наран, Даваат, Булаг, Баянбулаг баг/,
- Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/,
- Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Их залуу баг/,
- Өрхийн эмнэлгийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум, Дэнж, Уртын гол, Шанд, Их залуу, Оюут, Согоот, Уурхайчин баг/.

Орхон аймгаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах дуусаагүй шилжих болон шинээр эхлэх төсөл, арга хэмжээний саналыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээр хэлэлцүүлээгүй нь Засгийн газрын 348 дугаар тогтоолоор баталсан “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг журам”-ын 4.2.4-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслийн саналаа үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу боловсруулж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Төсөвт өртөг нэмэгдэх, царцаасан төсөл, арга хэмжээ үүсгэхгүйн тулд хөрөнгө оруулалтын явц, байдал, цаашдын төлөвийн талаар аймгийн ИТХ-аар хэлэлцүүлсэн саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх шаардлагатай байна.

А.2 Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоог хууль, журамд нийцүүлсэн байна.

Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-д заасны дагуу архитектур төлөвлөлтийн даалгаврыг аймгийн ГХБХБГ боловсруулж, ХББЗА ОНӨААТҮГ-ын захирал буюу ерөнхий архитектор, зураг, төсөв боловсруулах ажлын даалгаврыг Хотын захирагчийн алба боловсруулж, аймгийн Засаг дарга баталсан байна.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 13 төсөл, арга хэмжээнээс зураг төсөв шаардахгүй 3, зураг төсөвтэй хэрэгжих 10 төсөл, арга хэмжээ байна. Эдгээр 10 төсөл, арга хэмжээний инженер геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл иж бүрэн бүрдсэний дараа зураг төсөл зохиох ажлын даалгаврыг боловсруулжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг судалгаа №1-т харуулав.

Хотын захирагчийн алба нь 6 төсөл, арга хэмжээний зураг төсөлд явцын хяналт хэрэгжүүлэн, зохиогчийн бодит гүйцэтгэлийг баталгаажуулж, хүлээн авсан байна. Их засварын 2 төсөл, арга хэмжээний зураг төсвийг Хотын захирагчийн алба гүйцэтгэжээ. Харин 2 төсөл, арга хэмжээ БХБЯ-нд түлхүүр гардуулах нөхцөлөөр гэрээ байгуулсан байна.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 8 төсөл, арга хэмжээний зураг, төсөлд магадлал хийлгэж, магадлалын ерөнхий дүгнэлт гарсан ба их засварын 2 төсөл, арга хэмжээний зураг төсөлд магадлал хийлгэх шаардлагагүй байна.

Орхон аймаг төсвөөс санхүүжүүлсэн 6 төсөл, арга хэмжээний зураг, төсөл боловсруулах зөвлөхийн гэрээнд магадлалаар баталгаажуулсан зураг, төсөл

хүлээн авах, улсын магадлалаар баталгаажуулах зардал, холбогдох татвар хураамж гэрээний үнэд багтаасан байна.

2020 оны төсвийн тухай хууль батлагдсанаас хойш магадлал хийгдэж, төсөвт өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна.

А.3 УИХ-аар төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг баталсаар байна.

УИХ-аар Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль батлахдаа Орхон аймагт шинээр хэрэгжих 13 төсөл, арга хэмжээний төсөвлөлтийн шаардлага бүрэн хангаагүй байхад баталсан байна.

Тухайлбал шинээр хэрэгжүүлэх 2 төсөл, арга хэмжээнд газрын зөвшөөрөл олгоогүй буюу УИХ-аар хөрөнгө оруулалтын жагсаалт баталсны дараа олгосон байна. Үүнд:

- Хүүхдийн хөгжил, хамгааллын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/
- Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/

Мөн шинээр хэрэгжүүлэх 8 төсөл, арга хэмжээг УИХ-аар хөрөнгө оруулалтын жагсаалт баталсны дараа техникийн нөхцөлүүд, инженер геологийн дүгнэлт, магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулж, зураг төсөлгүй баталсан байна. Үүнд:

- Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/
- Багийн явган хүний зам, тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант, Цагаанчулуут, Наран, Даваат, Булаг, Баянбулаг, Уртбулаг, Бүрэнбүст баг/
- Явган хүний зам, тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант, Цагаанчулуут, Наран, Даваат, Булаг, Баянбулаг баг/
- Ахмадын өргөөний барилга /Орхон, Жаргалант сум/
- Хүүхдийн хөгжил, хамгааллын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/
- Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/
- Багийн цогцолбор барилга /Орхон, Баян-Өндөр сум, Яргуйт баг/
- Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Их залуу баг/

Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг УИХ-аар тойм дүнгээр жил бүр баталсаар байгаа зөрчил давтан гарсан байна.

- Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/ Магадлалын дүгнэлтээр баталгаажсан төсөвт өртөг 3,943.6 сая төгрөг бөгөөд барилга угсралтын ажлын өртгөөр тендер зарлаж, гэрээ байгуулсан байна. 1,457.1 сая төгрөгийн ИШС-ний ажлууд хийгдэхгүйгээс ашиглалтгүй хөрөнгө болж, орхигдох эрсдэл үүсэхээр байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасантай нийцэхгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн мэдээллийг pimis.publicinvestment.gov.mn цахим системээр 2019 оноос эхлэн гүйцэтгэсэн хэдий ч программ шинэчлэлээс шалтгаалан архив үүсээгүй, дэлгэрэнгүй мэдээлэл болон Сангийн яам хэрхэн хяналт хэрэгжүүлснийг нягтлах боломжгүй байлаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгасан төсөл, арга хэмжээ бүрээр хийсэн судалгаа, орон нутгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон тооцоолол, холбогдох мэдээллийг агуулсан мэдээллийн цахим сан үүсгэх шаардлагатай байна.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баталсан 2020-2021 онд хэрэгжих, шинээр эхлэх 1,262.6 – 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 5 төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” гэж заасан төсөвлөлтийн зарчмыг хангахгүй, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүйгээр баталсан байна.

Хүснэгт 5 Санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүй баталсан төсөл, арга хэмжээ /сая төгрөг/

д/д	ТАХ-ний нэр	хэрэгжих хугацаа		Баталсан		Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан байх хэмжээ	Зөрүү /тайлант онд санхүүжих-тэнцүү хуваарилсан байх/
		Эхлэх	Дуусах	төсөвт өртөг	тайлант онд санхүүжих дүн		
1	Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/	2020	2021	2,050.0	300.0	1,025.0	(725.00)
2	Багийн цогцолбор барилга /Орхон, Баян-Өндөр сум, Яргуйт баг/	2020	2021	2,050.0	400.0	1,025.0	(625.00)
3	Хүүхдийн хөгжил, хамгааллын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/	2020	2021	1,262.6	300.0	631.3	(331.30)
4	Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/	2020	2021	2,000.0	400.0	1,000.0	(600.00)
5	Багийн явган хүний зам, тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант, Цагаанчулуут, Наран, Даваат, Булаг, Баянбулаг, Уртбулаг, Бүрэнбүст баг/	2020	2021	2,000.0	500.0	1,000.0	(500.00)
ДҮН				9,362.6	1,900.0	4,681.3	(2,781.3)

2018 - 2019 онд хэрэгжүүлэхээр баталсан 2 төсөл, арга хэмжээг улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүйгээс тухайн онд царцааж, 2021 оны жагсаалтад батлагдсан бол 2021 онд 2 төсөл, арга хэмжээ царцаагдахаар болжээ.

Орхон аймагт 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 24 төсөл, арга хэмжээнээс 3 нь тоног төхөөрөмж худалдан авах, 2 нь их засвар, 19 нь барилга байгууламж барих төсөл, арга хэмжээ бөгөөд Төсвийн тухай хуулийн 4.1.24-т “хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” гэсэн заалттай нийцэж байна.

БҮЛЭГ 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт бүрэн хангагдахгүй байгаа нь төсөвлөлтөөс шалтгаалсаар байна.

Б.1 Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг УИХ-аар баталснаас шалтгаалан гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажиллагаа төлөвлөсөн хугацаанаас хоцорсоор байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжих 9 төсөл, арга хэмжээний худалдан авах, гэрээ байгуулах, санхүүжүүлэх эрхийг холбогдох салбарын сайдын багцаас Орхон аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.13-т “захиалагч хуулийн 46.3-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх” гэж заасны дагуу шилжүүлэхээр байтал 8-40 хоногоор хугацаа хоцроосоор байгаа нь худалдан авах ажиллагаа оройтож зохион байгуулагдах, амжилтгүй болох, цаг хугацаа алдах эрсдэл үүсгэж байна.

Дүрслэл 2 Эрх шилжүүлсэн хугацаа хоцроосон байдал



Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтад батлагдаж, эрх шилжсэн шинээр хэрэгжих 8,312.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,850.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 9 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 5, харьцуулалтын аргаар 4 худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулсан байна.

5 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжих бөгөөд 4 төсөл, арга хэмжээг тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ТЕЗ-даас эрх шилжүүлэх хугацааг тооцоолон төлөвлөдөг байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг баталснаас шалтгаалан магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг, төсвийг хүлээн авсны дараа тендер зарладгаас шалтгаалан худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулаагүй, 13-87 хоногоор хоцорсон байна. Тухайлбал:

- 5 ажлын үнэлгээний хороог 14 хоног,
- нийт ажлуудын тендер шалгаруулалт 8-60 хоног,
- нийт ажлуудын гэрээ байгуулах явц 13-64 хоногоор хоцорчээ.

Орхон аймгийн ТЕЗ-д эрх шилжсэн 9 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад 2 үнэлгээний хороо байгуулжээ.

Үнэлгээний хороонд ажилласан гишүүд худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн, мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, аймгийн ИТХ-аас томилсон иргэдийн төлөөллийг оролцуулж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангасан байна.

Үнэлгээний хороод Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар батлагдаж, 2019 оны нэмэлт өөрчлөлт оруулсан “Бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичиг”-ийг баримтлан боловсруулсан байна.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороод урилгыг Монголын мэдээ сонинд нийтлүүлэн, tender.gov.mn болон erdenet.mn цахим хуудсанд байршуулж ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан бөгөөд тендерт оролцогчид гомдол гаргаагүй байна. Сангийн яам ТЕЗ-ийн 2020 оны худалдан авах ажиллагааг 84 хувиар үнэлсэн байна.

Аймгийн ОНӨГ нь Орхон аймгийн 2020 оны худалдан авах ажиллагааны тайланг улирал бүр тайлагнаж, erdenet.mn, shilendans.gov.mn болон tender.gov.mn цахим хуудсанд тогтмол мэдээлж хэвшсэн байна.

ТЕЗ-ийн 2020 онд хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг 68.7%-тай хангуулсан боловч 2021 оны төсөвт 2 төсөл, арга хэмжээ батлагдаагүйгээс бүрэн дуусахгүй байхаар болсон байна.

УИХ-аас зураг төсөвгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ баталснаас шалтгаалан зураг төсөв боловсруулах, магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулахад хугацаа алдсанаар худалдан авах ажиллагаа хойшилж, улирлын шинж чанартай бүтээн байгуулалтын чанар байдалд нөлөөлж, он дамжсаар байна.

Орхон аймагт 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 24, өмнөх оноос шилжсэн дуусаагүй 19, нийт 43 төсөл, арга хэмжээнээс 2021 онд шилжин хэрэгжих 11, бүрэн дууссан 20, хэрэгжиж дууссан боловч улсын комисс ажиллаагүй 2, 3-92.5%-ийн гүйцэтгэлтэй 10 төсөл, арга хэмжээ байх ба хэрэгжилт 68.7 хувьтай хангагджээ.

Хүснэгт 6 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл						
Гүйцэтгэлийн хувь		дуусаагүй				Нийт TAX
		эрх шилжсэн TAX	эрх шилжээгүй TAX	эрх шилжсэн TAX	эрх шилжээгүй TAX	
Бүрэн дууссан	улсын комисс ажилласан	10	1	6	3	20
	улсын комисс ажиллаагүй	2				2
Бүрэн дуусаагүй	1-20% гүйцэтгэлтэй			1		1
	21-50% гүйцэтгэлтэй					-
	51-75% гүйцэтгэлтэй					-
	76-99% гүйцэтгэлтэй	3		3		6
2020 онд царцаасан TAX		2	1			3
2021 онд шилжин хэрэгжих TAX				6	5	11
Нийт дүн		17	2	16	8	43
Гүйцэтгэлийн хувь						68.75

2020 онд царцаасан 3, бүрэн дуусаагүй 7 төсөл, арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээ нь төсөвт өртөг нэмэгдүүлэх, 5 нь гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас, 1

нь зураг төсөв өөрчлүүлэх шалтгаанаас бүрэн дуусаагүй бөгөөд улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад 3 төсөл, арга хэмжээ батлагдаж, 2 төсөл, арга хэмжээ бүрэн дуусахгүй байхаар болсон байна.

Хүснэгт 7 Төсөл, арга хэмжээний хэрэгжилт бүрэн дуусаагүй шалтгаан

Гүйцэтгэлийн хувь		ТАХ-ний тоо	Дуусаагүй шалтгаан		
			УИХ-аар төсөвт өртөг нэмэгдүүлэх	гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас	зураг төсөв өөрчлөх
2020 онд царцаасан ТАХ	70-84% гүйцэтгэлтэй	2	1	1	
	85-99% гүйцэтгэлтэй	1	1		
Бүрэн дуусаагүй	1-20% гүйцэтгэлтэй	1	1		
	76-99% гүйцэтгэлтэй	6	1	4	1
Нийт дүн		10	4	5	1

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 оноос шилжсэн, 2020 онд хэрэгжсэн эрх шилжсэн 33 төсөл, арга хэмжээнд ХББЗА ОНӨААТҮГ, эрх шилжээгүй 10 төсөл, арга хэмжээнд аймгийн ГХБХБГ захиалагчийн тавих үе шатны явцын болон техникийн хяналтыг хэрэгжүүлжээ. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 25 төсөл, арга хэмжээнд Барилгын хөгжлийн төв хяналт хэрэгжүүлж, хэрэгжүүлсэн ажлын тайланг аймгийн ЗДТГ-т ирүүлжээ.

Гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний дагуу барилгын ажлын үе шат бүрд захиалагчийн хяналтыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хэрэгжүүлж, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг фото зураг, холбогдох баримтаар баталгаажуулжээ.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн тоног төхөөрөмж нийлүүлэх 2 төсөл, арга хэмжээгээр 3 сургууль 15 нэр төрлийн 64.9 сая төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг хүлээн авч, бүртгэж тайлагнасан байна.

Эрх шилжээгүй өрхийн эмнэлгийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум, Дэнж, Уртын гол, Шанд, Их залуу, Оюут, Согоот, Уурхайчин баг/-ийн хүрээнд аймгийн 5 өрхийн эрүүл мэндийн төвд 12 нэр төрлийн 322.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ЭМЯ-аас өгснийг тухайн байгууллагууд хүлээн авч, бүртгэлд тусгасан байна.

Гүйцэтгэгч байгууллагуудын явцын гүйцэтгэлийн баримт болон санхүүжилтийн гүйцэтгэлийн баримтуудыг тулгахад зориулалтын бус зарцуулсан байх нөхцөл үүсээгүй байна.

Тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлт, хүчин чадал болон төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэлийг тулган баталгаажуулах байсан хэдий ч ковид цар тахлаас шалтгаалан хэрэгжүүлээгүй болно.

Б.3 Захиалагчийн гэрээний хэрэгжилтэд тавих хяналтын үр дүн сайжирч байна.

Захиалагчийн хяналтыг ХББЗА ОНӨААТҮГ, ГХБХБХГазар, зохиогчийн хяналтыг зураг, төсөв гүйцэтгэгч компаниуд хэрэгжүүлсэн бөгөөд Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.4, 37.1.5, “Барилгын захиалагчийн хяналтын дүрэм”-ийн 2.2, 3.1.4, 3.4, 3.6, 3.12, 3.14 дэх заалтуудыг мөрдсөн байна.

Аудитын явцад захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ажлын тайлан, холбогдох материалыг авч санхүүжилтийн баримттай тулгасан болно. Барилгын хөгжлийн төв,

аймгийн ГХБХБГ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 25 төсөл, арга хэмжээ бүрээр хяналт хэрэгжүүлсэн ажлын тайланг нэгтгэж, гаргасан байна.

Эрх шилжсэн төсөл, арга хэмжээнүүдэд ХББЗА ОНӨААТҮГ хяналт хэрэгжүүлсэн бөгөөд 2020 онд төсөл, арга хэмжээ бүрээр нэгдсэн дүгнэлт гарган баталгаажуулж, хяналт хэрэгжүүлсэн талаарх мэдээллийг нэгтгэжээ.

Эрх шилсэн төсөл, арга хэмжээний зохиогчийн хяналтыг ХББЗА ОНӨААТҮГ холбогдох аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулж, хянасан байна.

Үе шатны хяналт сайжирч байгаа хэдий ч үр дүнг аудитын явцад тулган баталгаажуулах төлөвлөгөө ковид цар тахлаас шалтгаалж хэрэгжүүлээгүй тул орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар үр дүнг үнэлнэ.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын дагуу захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн 12 төсөл, арга хэмжээнд 3,005.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Сангийн яам 1 төсөл, арга хэмжээний эрхийг нээхдээ бодит гүйцэтгэлээс 0.6 сая төгрөгөөр дутуу дүнгээр нээсэн байна.

Хүснэгт 8 2020 онд эрх нээж, олгосон төсвийн санхүүжилт /сая төгрөг/

д/д	ТЕЗ	2020 онд баталсан			эрх нээсэн		олгосон		барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан	
		ТАХ-ний тоо	төсөвт өртөг /сая.төг/	санхүүжих дүн /сая.төг/	ТАХ-ний тоо	санхүүжих дүн /сая.төг/	ТАХ-ний тоо	санхүүжилт дүн /сая.төг/	ТАХ-ний тоо	санхүүжилт дүн /сая.төг/
1	ХНХС	2	2,062.6	600.0	2	600.0	2	600		
2	БХБС	1	3,400.0	3,400.0	1	98.9			1.0	98.9
3	БСШУС	6	4,662.0	1,162.0	5	1,128.0	5	527.4	5.0	600.6
4	ЗТХС	1	2,894.0	694.0						
5	ЭХС	1	1,500.0	850.0						
6	СС				1	799.0	1	527.4	1.0	271.6
7	ЗГХЭГ	5	9,960.0	2,560.0	4	1,446.9	4	1350.4	4.0	96.5
Нийт дүн		16	24,478.6	9,266.0	13	4,072.8	12	3,005.2	11	1,067.6

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, ГХБХБГ, ХББЗА ОНӨААТҮГ-ууд нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлж, үр дүнг нэгтгэж хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Б.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар ЗГ-аас гаргасан шийдвэр үр дүнтэй байна.

Засгийн Газрын 2019 оны 430 дугаар тогтоолоор 2019 оны эцэст банкны урьдчилгаа төлбөрийн баталгаанд 10 төсөл, арга хэмжээний 2,146.5 сая төгрөгийн, орон нутгийн барьцаа хөрөнгийн дансанд 8 төсөл, арга хэмжээний 1,449.0 сая төгрөгийн санхүүжилтийг байршуулсан. Эдгээр санхүүжилтийг олгохдоо Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын дагуу захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн, Сангийн яамаар хянуулж, санхүүжилтийг олгожээ.

Хүснэгт 9 Урьдчилгаа төлбөрийн баталгаа болон барьцаа хөрөнгийн дансаар олгосон санхүүжилт /сая төгрөг/

ТАХ/санхүүжилт	банкны урьдчилгаа төлбөрийн баталгаанд байршуулсан			барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан			
	2019.12.31-ний үлдэгдэл	2020 онд олгосон	2020.12.31-ний үлдэгдэл	2019.12.31-ний үлдэгдэл	2020 онд эрх нээсэн	2020 онд олгосон	2020.12.31-ний үлдэгдэл
ТАХ-ний тоо	10	3	7	8	13	4	4
санхүүжих дүн /сая төгрөг/	2,146.5	355.7	1,790.8	1,449.0	4,072.8	4,070.4	1,451.4

Орон нутгийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төсөл арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэж олгохдоо 6 төсөл арга хэмжээний 46.7 сая төгрөгийн техник хяналтын зардлыг холбогдох дансанд шилжүүлээгүй, 1 төсөл, арга хэмжээний 3.5 сая төгрөгийн техник хяналтын зардлыг суутгахгүй олгосон, өмнөх оны алдааг давтан гарсан нь Төсвийн тухай хуулийн 41.2.6-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх”, Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.6-д “Барилгын ажлын зардал, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа /цаашид “ТЭЗУС” гэх/, техник, эдийн засгийн үндэслэл /цаашид “ТЭЗҮ” гэх/, зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт, материал, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчиж байна. Иймд албан шаардлага хүргүүлээ.

Өмнөх оны санхүүжилт шилжүүлэх, суутган авах тооцооны үнэн зөв байдалд аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд 20 төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авч, улсын болон орон нутгийн төсөвт байгууллагуудын эзэмшилд шилжүүлэн, бүртгэж тайлагнасан байна.

Хүснэгт 10 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2020 онд ашиглалтад хүлээн авч, бүртгэсэн хөрөнгө /сая.төгрөг/

Хөрөнгө оруулалтын төрөл	2018 он		2019 он		2020 он	
	ТАХ-ний тоо	Дүн /сая.төгрөг/	ТАХ-ний тоо	Дүн /сая.төгрөг/	ТАХ-ний тоо	Дүн /сая.төгрөг/
барилга байгууламж			5	5,149.3	14	11,680.6
их засвар	3	199.9	2	252.7	2	82.3
тоног төхөөрөмж			1	86.9	3	387.6
инженерийн шугам сүлжээ	2	2,538.5	1	1,437.7	1	1,424.9
Нийт	5	2,738.4	9	6,926.6	20	13,575.4

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй дуусаагүй 15 төсөл, арга хэмжээний 16,242.9 сая төгрөгийн барилга, байгууламжийг ОНӨГ-ын бүртгэлд 4 төсөл, арга хэмжээг 1,199.3 сая төгрөгөөр илүү, 8 төсөл, арга хэмжээний 4,900.2 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1-д “Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр

эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргаа харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана” гэсэн заалттай нийцэхгүй байна. Дуусаагүй барилгад барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн дүнгээр бүртгэх албан шаардлага хүргүүлэв.

Орон нутгийн өмчийн бүртгэл, тайлагналыг хянах аймгийн ЗДТГ-ын СТСХ нь холбогдох эрх бүхий байгууллагаас тайлан, судалгааг авч дуусаагүй барилга, байгууламжийг бүртгэхэд нэгдсэн удирдлагаар хангах шаардлагатай байна.

2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон 20 төсөл, арга хэмжээнээс дараах үр нөлөө гарчээ. Үүнд:

- 450 ортой 3 цэцэрлэг, 100 ортой 1 хүүхдийн дотуур байр ашиглалтад орсноор 432 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж, 82 хүн ажлын байраар хангагдсан байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх арга хэмжээг авч байгаа хэдий ч орон нутгийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн тодорхойлж чадахгүй байна.
- Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоог хууль, журамд нийцүүлсэн байна.
- УИХ-аар төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг баталсаар байна.
- Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг УИХ-аар баталснаас шалтгаалан гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажиллагаа төлөвлөсөн хугацаанаас хоцорсоор байна.
- Захиалагч гэрээний хэрэгжилтийг 68.7%-тай хангуулсан боловч 2 төсөл, арга хэмжээ 2021 онд бүрэн дуусахгүй байхаар болсон байна.
- Захиалагчийн гэрээний хэрэгжилтэд тавих хяналтын үр дүн сайжирч байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар ЗГ-аас гаргасан шийдвэр үр дүнтэй байна.

Аудитаар нийт 6,149.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 6,149.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 5 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 1 саналыг хүргүүллээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Зураг, төсөв магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажаагүй төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулан, төсөвт өртөг нэмэгдүүлж батлуулахаар төсөл, арга хэмжээг царцааж байгаад асуудлуудыг таслан зогсоох, тогтолцоог оновчтой болгох талаар тайланд тусгах.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат-д

- Орхон аймгаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах дуусаагүй шилжих болон шинээр эхлэх төсөл, арга хэмжээний саналыг ИТХ-ын тэргүүлэгчдээр хэлэлцэн, төсөвт өртөг нэмэгдэх, царцаасан төсөл, арга хэмжээ үүсгэхгүй байхад анхаарах.

Аймгийн Засаг дарга С.Батжаргал-д

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад хүргүүлэх саналыг аймгийн нийгэм, эдийн засгийн салбарын бодлого, орон нутгийн хэрэгцээ шаардлагатай уялдуулах.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгасан төсөл, арга хэмжээ бүрээр цахим мэдээллийн сан үүсгэх.
- Санхүүжилт олгохдоо холбогдох дансанд төвлөрүүлэх санхүүжилтийг шилжүүлээгүй, суутгаагүй алдаа давтагдаж байгаад аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дотоод хяналтыг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх.
- Орон нутгийн өмчийн бүртгэл, тайлагналыг хянах аймгийн ЗДТГ-ын СТСХ нь холбогдох эрх бүхий байгууллагаас тайлан, судалгааг авч дуусаагүй барилга, байгууламжийг бүртгэхэд нэгдсэн удирдлагаар хангах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Холбогдох байгууллагын санал:



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртбулаг баг,
Амарын талбай, Нутгийн удирдлагын ордон,
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621
И-мэйл: info@erdenet.mn

2021. 05. 04 № 07 / 915
танай -ны № -т

Аудитын тайлангийн тухай

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

В. Дамбаа
2021. 05. 04
Тайланг өргөмт оруулах
шаардлагатай өөрх
сүүлийн төлөвлөгөөнийх.

Тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно. Тайланд тусгагдсан “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан төлөвлөлтийн шаардлага хангахгүй 8 төсөл арга хэмжээний хувьд УИХ гишүүд нь өөрийн эрх хэмжээний хүрээнд тойрогтоо санаачилан батлуулсан.

УИХ гишүүн Д.Дамба-Очирын санаачлагаар:

- Багийн явган хүний зам, тохиолт /Орхон Баян-Өндөр сум, Рашаант, Цагаанчулуут, Наран, Даваат, Булаг, Баянбулаг, Уртбулаг, Бүрэнбүст баг/,
- Явган хүний зам, тохиолт /Орхон Баян-Өндөр сум, Рашаант, Цагаанчулуут, Наран, Даваат, Булаг, Баянбулаг баг/

УИХ гишүүн О.Баасанхүү санаачлагаар:

- Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Их залуу баг
- Өрхийн эмнэлгийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум, Дэнж, Уртын гол, Шанд, Их залуу, Оюут, Согоот, Уурхайчин баг/

УИХ гишүүн О.Содбилэг санаачлагаар:

- Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/
- Ахмадын өргөөний барилга /Орхон, Жаргалант сум/
- Сургуулийн барилга 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/

Мөн 2013 төлөвлөсөн 2014 онд хэрэгжиж эхлээд зогссон байсан Хөдөө аж ахуйн их сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон, Баян-Өндөр сум/ төсөл арга хэмжээг дэмжиж батлуулсан болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА С.ДАВААДОРЖ



D:/My documents/A-4 doc
6121030743

Саналд өгсөн тайлбар: Ирүүлсэн санал, баримт материалд үндэслэн дараах тайлбарыг өгч байна.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс төсөвлөлтийн шаардлага хангаагүй 8 төсөл, арга хэмжээний хувьд УИХ-ын гишүүдийн санаачилгаар батлуулсан тайлбар ирүүлсэн бөгөөд асуудлыг аудитын тайланд тусгасан тул тайланд өөрчлөлт оруулахгүй байхаар шийдвэрлэлээ.